АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2024/04-НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2024 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор В.Цогжаргал<br>Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**........ 8
**3.1 Зөвлөмж**........ 8
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 8

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 166

танай ______________-ны №______________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БУЯННЭМЭХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариат сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 89.86 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,270,099.0 | 917,590.7 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 868,901.8 | 421,492.8 |
| **33** | **АВЛАГА** | 337,698.0 | 418,563.6 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 63,499.1 | 77,534.3 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 3,087,340.1 | 3,137,803.8 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,087,340.1 | 3,137,803.8 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 3,050,687.9 | 3,101,151.6 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 36,652.2 | 36,652.2 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,357,439.0** | **4,055,394.5** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 9,157.9 | 0.0 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,157.9 | 0.0 |
| **41300** | **Өглөг** | 9,157.9 | 0.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 4,348,281.1 | 4,055,394.5 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,348,281.1 | 4,055,394.5 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 377,027.4 | 377,027.4 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,606,832.6 | 3,313,946.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 364,421.1 | 364,421.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,357,439.0** | **4,055,394.5** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,199,034.3** | **2,258,691.8** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 897,343.7 | 603,902.3 |
| **110** | **Орлогын албан татвар** | 291,362.7 | 371,434.3 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 291,362.7 | 371,298.3 |
| **1102** | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 136.0 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 107,378.4 | 116,182.6 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 498,602.6 | 116,285.3 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 324,975.2 | 391,224.2 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 324,975.2 | 391,224.2 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 976,715.4 | 1,263,565.3 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,451,468.5** | **1,990,195.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,451,468.5 | 1,990,195.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,399,662.2 | 1,985,195.3 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 396,628.4 | 512,732.8 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,644.8 | 64,312.9 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 483,261.2 | 27,498.2 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 45,812.4 | 68,468.4 |
| **2105** | Нормативт зардал | 527.8 | 0.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,269.3 | 22,212.5 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 4,160.0 | 10,578.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,158.5 | 875,109.2 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 369,199.8 | 404,283.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,806.3 | 5,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **747,565.8** | **268,496.5** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 8,083,004.4 | 561,383.1 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-7,335,438.5** | **-292,886.6** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,091,432.5** | **2,009,053.4** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 897,343.7 | 603,902.3 |
| **110** | **Орлогын албан татвар** | 291,362.7 | 371,434.3 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 291,362.7 | 371,298.3 |
| **1102** | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 136.0 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 107,378.4 | 116,182.6 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 498,602.6 | 116,285.3 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 34,109.8 | 40,433.6 |
| **1181** | **Газрын төлбөр** | 49,505.2 | 42,520.0 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 414,987.6 | 33,331.7 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 217,373.4 | 141,585.8 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 217,373.4 | 141,585.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 976,715.4 | 1,263,565.3 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,168,453.2** | **1,641,925.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,168,453.2 | 1,641,925.4 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,048,244.7 | 1,636,925.4 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 396,628.4 | 511,939.6 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,789.7 | 63,141.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 483,261.2 | 27,759.6 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 38,835.2 | 66,295.2 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,115.3 | 23,220.5 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 4,160.0 | 10,578.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 38,477.5 | 880,433.8 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,977.4 | 53,557.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 120,208.4 | 5,000.0 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **922,979.4** | **367,128.0** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 389,031.9 | 627,537.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 389,031.9 | 627,537.0 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 389,031.9 | 627,537.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-389,031.9** | **-627,537.0** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-208,000.0** | **-187,000.0** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 208,000.0 | 187,000.0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **325,947.4** | **-447,409.0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 542,954.4 | 868,901.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 868,901.8 | 421,492.8 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 10,126,728.2 | 10,126,728.2 |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | 1,556,991.4 | 1,556,991.4 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 11,683,719.6 | 11,683,719.6 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | -7,335,438.5 | -7,335,438.5 |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,348,281.1 | 4,348,281.1 |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 4,348,281.1 | 4,348,281.1 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 4,348,281.1 | 4,348,281.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -292,886.6 | -292,886.6 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,055,394.5 | 4,055,394.5 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,752,775.60 | 2,444,132.30 | 308,643.30 | 88.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,766,715.00 | 1,683,749.20 | 82,965.80 | 96.35 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,761,715.00 | 1,678,749.20 | 82,965.80 | 96.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 527,372.10 | 511,939.60 | 15,432.50 | 97.89 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,859.00 | 63,141.60 | 2,717.40 | 97.27 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 525,781.20 | 519,902.00 | 5,879.20 | 95.34 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 71,646.70 | 70,660.50 | 986.20 | 98.41 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 105,978.50 | 97,360.20 | 8,618.30 | 98.87 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,738.00 | 10,578.00 | 160.00 | 99.85 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 401,239.50 | 352,067.40 | 49,172.10 | 97.37 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,100.00 | 53,100.00 | 0.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000.00 | 5,000.00 | 0.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,000.00 | 5,000.00 | 0.00 | 100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 678,930.60 | 573,383.10 | 105,547.50 | 50.65 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 307,130.00 | 187,000.00 | 120,130.00 | 90.86 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,752,775.60 | 2,373,496.00 | 379,279.60 | 85.99 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,734,370.90 | 2,260,643.80 | -526,272.90 | 94.77 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,018,404.70 | 112,852.10 | 905,552.60 | 31.68 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 254,624.10 | -254,624.10 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 183,987.80 | -183,987.80 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 64 | 64 | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 31 | 28 | | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 31 | 28 | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 12,330.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 12,330.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,330.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 589.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,283.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 457.1 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 12,330.1 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,330.1 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **23,435.6** мянган төгрөгийн зөрчил[1] илэрч зөрчлийг арилгуулах 1 зөвлөмж хүргүүллээ.

### 3.1 Зөвлөмж

#### *3.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой*

*Илрүүлэлт:* Хоршоо хөгжүүлэх санд 12 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн 18,904.1 мянган төгрөгийн үндсэн зээл, 4,531.5 мянган төгрөгийн хүү нийт 23,435.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах .

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | 23,435.6 | - | - | - | - | 1 | 23,435.6 | - | - | - | - |
| **Нийт дүн** | **1** | **23,435.6** | | | | | **1** | **23,435.6** | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.